

Төрийн албаны зөвлөлийн
2021 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн
102 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- ☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- ☒ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг
баталсан огноо:

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт,
зохицуулалтын газар

Эмнэлгийн тоног төхөөрөмжийн газар

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Нийслэлийн эрүүл мэндийн
байгууллагын эмнэлгийн тоног
төхөөрөмжийн шалгалт тохируулгын
асуудал хариуцсан мэргэжилтэн

Дэс түшмэл, ТЗ-6

Ажлын цаг:

Ажлын байрны албан ёсны байршил:

Ажлын өдрийн 8 цаг

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1
дүгээр хороо, UBH center, 8 дугаар давхар

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл:

Хэвийн

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Эм, эмнэлгийн хэрэгслийн талаар төрийн бодлого, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагын эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийх, симулятор, анализаторын гадаад хяналт, баталгаажуулалтын тогтвортой байдлыг хангах, өргөжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж, үр дүнг газрын даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1. Эм, эмнэлгийн хэрэгслийн талаар төрийн бодлого, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах;
2. Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагын эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийх, шалгалт тохируулгын симулятор, анализаторын гадаад хяналт, баталгаажуулалтын тогтвортой байдлыг хангах, өргөжүүлэх;
3. Нэгжийн үйл ажиллагаанд оролцож, дэмжлэг үзүүлэх, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх;
4. Хууль тогтоомжоор хүлээсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Эмнэлгийн тоног төхөөрөмжийн үйл ажиллагаанд холбогдох асуудлаар төрийн бодлого, хууль тогтоомж, тогтоолын хэрэгжилтийг хангах, тайлагнах;	Төрийн бодлого, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хангагдаж, заасан хугацаанд тайлагнасан байна.	Г
	2.Эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт тохируулгын үйл ажиллагаатай холбоотой хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал боловсруулах;	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт тохируулгын үйл ажиллагаатай холбоотой хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал боловсруулсан байна.	Г
2 дугаар зорилтын хүрээнд	1.Эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийх, үр дүн боловсруулах, хүргүүлэх;	Эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийж, үр дүн боловсруулан хүргүүлсэн байна.	Г
	2.Эмнэлгийн тоног төхөөрөмжийн үр дүнг нэгтгэх, тайлагнах;	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн үр дүнг нэгтгэж, тайлагнасан байна.	Г
	3.Шалгалт тохируулгын симулятор, анализаторыг олон улсын хэмжил зүйн байгууллагаар баталгаажуулалт хийлгэх үйл ажиллагааг зохион байгуулах;	Шалгалт тохируулгын симулятор, анализаторыг олон улсын хэмжил зүйн байгууллагаар баталгаажуулалт хийлгэсэн байна.	Г
	4.Эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт тохируулгын үйл	Эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийх хэрэгцээ	Г



	ажиллагааны хэрэгцээ шаардлагыг судлах;	шаардлагыг судалсан байна.	
3 дугаар зорилтын хүрээнд	1.Тушаал шийдвэр, цаг үеийн болон бусад асуудлаар удирдлагыг үнэн зөв бодит мэдээллээр хангах, өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлэх;	Үүрэг даалгаврыг хугацаанд гүйцэтгэж, эргэн тайлагнасан байна.	Г
	2.Газрын даргатай гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, арга хэмжээний биелэлтийг хангаж, тогтоосон хугацаанд нь тайлагнах, үр дүнг үнэлж дүгнүүлэх;	Гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн тайлан, үнэлгээ.	Г
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Төрийн албаны тухай хууль болон төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн дүрэм журам, байгууллагын дотоод журам, бусад төрийн албаны стандартыг мөрдөж хэрэгжүүлэх;	Төрийн албаны тухай хууль болон бусад стандарт дүрэм, журмыг зөрчөөгүйг нотлох дүгнэлт гаргасан байна.	Г
	2.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай болон Авлигын эсрэг хууль тогтоомжийг мөрдөх, хэрэгжилтийг хангах;	Эрх бүхий албан тушаалтанд ХАСХОМ-ыг өгсөн байдал, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байна.	Г
	3.Архив, албан хэрэг хөтлөлтийн заавар, журам, стандартад нийцсэн баримт бичгийн төсөл төлөвлөх, архивын нэгж бүрдүүлэх, байгууллага, нэгжийн өдөр тутмын дотоод үйл ажиллагаанд оролцох, зохион байгуулах.	Албан хэрэг хөтлөлтийн заавар, журам, стандартад нийцсэн байх хэрэгжилтийн тайлан.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.
Мэргэжил	- эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер - инженерчлэл /0788/
Мэргэшил	Төрийн албанд мэргэшүүлэх зохих багц сургалтад хамрагдаж төгссөн байх
Туршлага	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.

Ур чадвар	Дүн шинжилгээ хийх ур чадвар	- Судалгааны арга зүйн мэдлэгтэй байх; - Мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх; - Гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - Албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэхэд учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцох, бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх; - Бусад.
	Асуудал шийдвэрлэх ур чадвар	- Асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулж, үр дагаврыг хариуцах, үр дагаврын талаар удирдлагад танилцуулах; - Албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд асуудлыг хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - Саналын зөрүү, үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - Бусад.
	Багаар ажиллах ур чадвар	- Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж, бусдыг дэмжих, хамтран ажиллах; - Бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох; - Хамт олонч сэтгэлгээтэй, эерэг уур амьсгалыг дэмждэг байх; - Хувийн зохион байгуулалт, ажлын цаг ашиглалтын хувьд хамт олныг манлайлах; - Бусад.
	Бусад ур чадвар	- Англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах; - Компьютерын хэрэглээний программ, мэдээллийн технологийн дэвшилтэт аргыг ашиглах; - Бусдад хүндэтгэлтэй, соёлтой, адил тэгш хандах; - Кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх чадвартай байх;

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Эмнэлгийн тоног төхөөрөмжийн газрын дарга

<u>Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</u> Байхгүй	<u>Бусад харилцах субъект</u> 1. Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын бусад газар, хэлтсийн дарга 2. Яам, агентлаг, төрийн бусад байгууллага, тэдгээрийн ажлын албаны холбогдох албан тушаалтан 3. ЭМЯ-ны дэргэдэх Эмнэлгийн техник, тоног төхөөрөмжийн мэргэжлийн салбар зөвлөл, ерөнхий мэргэжилтэн, бусад мэргэжилтнүүд 4. Нутгийн захиргааны байгууллагын холбогдох албан тушаалтан 5. Төрийн бус байгууллага, Олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөрийн ажилтан 6. Эмнэлгийн тоног төхөөрөмж ханган нийлүүлэх байгууллага 7. Эрүүл мэндийн байгууллага
---	--

	8. Стандарт хэмжил зүйн асуудал эрхэлсэн төрийн байгууллага 9. Иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн байгууллага 10. Олон улсын хэмжил зүйн байгууллага
V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ	
<u>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</u>	<u>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</u>
<u>Албан тушаал:</u> АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ <i>М.М.М.М.</i> Л.НАМХАЙНОРОВ 2021 оны 3 дугаар сарын 26 ны өдөр	<u>Байгууллагын нэр:</u> ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ Шийдвэрийн огноо 21 03 17 Дугаар 102
Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:	
<u>Байгууллагын нэр:</u> ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР Шийдвэрийн огноо: 2021.03.26 Дугаар: А/15	
ДАРГА <i>Б. У.</i> (Гарын үсэг) <i>Б. Цогтсайхан</i> (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 2021 оны 3 дугаар сарын 26 ны өдөр	

